



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/335

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Насан туршийн суралцахуйн төвүүдийн баруун бүсийн төв, нэгжийн багш нарыг чадавхжуулах сургалт, зөвлөгөөн, ур чадварын уралдааныг 2026 оны 06 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 2,573,000 (хоёр сая таван зуун далан гурван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтын тайланг холбогдох журмын дагуу гаргаж, тайлагнахыг Насан туршийн суралцахуйн төвийн захирал (Х.Ундармаа)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

